

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн
Боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Засгийн газрын бүтцийн тухай хууль

Дагаж мөрдөх огноо:

2024.07.10

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:

2025.05.21

Байгууллагын нэр:

Эрүүл мэндийн яам

Нэгжийн нэр:

Нийгмийн эрүүл мэндийн бодлогын
газрын Халдварт өвчний хэлтэс

Албан тушаалын нэр:

Хэлтсийн дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Эрхэлсэн түшмэл, ТЗ-3

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпын гудамж 2, Засгийн газрын VIII
дугаар байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Халдварт өвчний сэргийлэлт, хяналтын урт, дунд, богино хугацааны бодлого, хэрэгжилтийн удирдлага, зохицуулалтаар хангах, гамшиг, олныг хамарсан өвчлөл, онцгой байдлын үед нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, хариу арга хэмжээ авах, эрсдэлийн үеийн харилцаа холбоог удирдах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Халдварт өвчний сэргийлэлт, хяналтын урт, дунд, богино хугацааны бодлого, хэрэгжилтийн удирдлага, олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварт өвчин, шинэ болон сэргэн тархаж байгаа халдварт өвчний сэргийлэлт, хяналт, тандалт, хариу арга хэмжээний бодлого, хэрэгжилтийн зохицуулалт, удирдлага зохион байгуулалтаар хангах;
2. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, зоонозын халдварт өвчний сэргийлэлт, хяналтын урт, дунд, богино хугацааны бодлого, "Нэг эрүүл мэнд"-ийн бодлогын хэрэгжилтийн нэгдсэн зохион байгуулалт, эрсдэлийн үеийн мэдээ, мэдээллийн чанар, хүртээмж, харилцаа, холбооны нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалт
3. Дархлаажуулалт болон дархлаажуулалт бүхий халдварт өвчний урт, дунд, богино хугацааны бодлого, хэрэгжилтийн нэгдсэн удирдлага зохион байгуулалт
4. ХДХВ/ДОХ,БЗДХ, сүрьеэ, вируст гепатит өвчний сэргийлэлт, хяналтын урт, дунд, богино хугацааны бодлого, хэрэгжилтийн нэгдсэн удирдлага, зохицуулалт
5. Нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавих, тайлагнах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Халдварт өвчний сэргийлэлт, хяналтын урт, дунд, богино хугацааны бодлого, хэрэгжилтийн удирдлага, зохицуулалтаар хангах	Бодлого боловсруулж нэгдсэн удирдлагаар хангасан байна. Мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.	Г, Х
	2. Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдварт өвчин, шинэ болон сэргэн тархаж байгаа халдварт өвчний сэргийлэлт хяналт, тандалт, хариу арга хэмжээний бодлого, хэрэгжилтийн зохицуулалт, удирдлага зохион байгуулалтаар хангах;	Хууль тогтоомж хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрсдэлийн үеийн мэдээ, мэдээллийн чанар, хүртээмж, харилцаа, холбооны нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалт сэргийлэлт, хяналтын урт, дунд, богино хугацааны бодлого хэрэгжилтийн удирдлага зохицуулалтаар хангах	Хариу арга хэмжээний төлөвлөлт хууль, тогтоомжинд нийцсэн байна.	Х, Ш
	2. "Нэг эрүүл мэнд"-ийн урт, дунд, богино хугацааны	Хуульд нийцүүлэн дүрэм, журмыг	Г, Х

	бодлого, хэрэгжилт, зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналт, тандалт, бэлэн байдал хариу арга хэмжээний бодлого боловсруулж, нэгдсэн удирдлагаар хангах	боловсруулах, бодлогын хэрэгжилтийг хангаж, мэргэжил арга зүйгээр хангасан байна.	
3 дугаар зорилтын хүрээнд	1. Дархлаажуулалт болон дархлаажуулалт бүхий халдварт өвчний сэргийлэлт хяналт, тандалт, бэлэн байдал, хариу арга хэмжээний бодлогыг хэрэгжилтийг хангуулах	Хяналт сэргийлэлт, хариу арга хэмжээний бодлогын хэрэгжилтийг хангаж мэргэжил арга зүйгээр хангасан байна.	Х,Ш
	2. Талбарын тархвар судлалын хөтөлбөр, Биотерроризмоос сэргийлэх чиглэлээр урт, дунд, богино хугацааны бодлого, хэрэгжилтийн зохицуулалт, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах	Хуульд нийцүүлэн дүрэм, журмыг боловсруулах, бодлогын хэрэгжилтийг хангаж, мэргэжил арга зүйгээр хангасан байна.	Г, Х, Ш
4 дүгээр зорилтын хүрээнд	1. ХДХВ/ДОХ, БЗДХ, сүрьеэ, вируст гепатит өвчний сэргийлэлт, хяналтын урт, дунд, богино хугацааны бодлого, эрх зүйн орчинг боловсронгуй болгоход нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах	Бодлогын хэрэгжилтийг хангаж, тогтолцоог бэхжүүлсэн байна.	Х,Ш
	2. ХДХВ/ДОХ, БЗДХ, вируст гепатит, сүрьеэ өвчний тандалт, судалгааг удирдлага зохион байгуулалтаар хангах	Тандалт судалгаанд үндэслэн шийдвэр гаргасан байна.	Х,Ш
5 дугаар зорилтын хүрээнд	1. Байгууллагын болон нэгжийн албан тушаалын чиг үүргийг гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэлтсийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагааг мэргэжил, арга зүйгээр хангах, батлах, дотоод тайлан мэдээг гаргах үйл ажиллагааны хэрэгжилтийг хангуулах	Гүйцэтгэлийн үр дүн зохих журмын дагуу үнэлж, дүгнэгдсэн байна.	Г, Х, Ш
	2. Албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, үйл ажиллагааны уялдааг зохицуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;	Хэлтсийн албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдан ажилласан байна.	Х, Ш
	3. Байгууллага, нэгжийн албан хаагчдын боловсруулсан албан бичиг, тушаалын шийдвэрийн төслийг хянах,	Албан хэргийг стандартын дагуу хөтөлсөн байна.	Х, Ш

	архив, албан хэрэг хөтлөлтөд хяналт тавих;		
	4. Хариуцсан асуудлаарх тайлагналт, албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах, хяналт тавих.	Тайлагналт, албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан байна.	Х, Ш
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.		
Мэргэжил	- эрүүл мэнд /091/ - нийгмийн эрүүл мэнд /098801/ - эрүүл ахуй, тархвар судлал /102101/;		
Мэргэшил	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.		
Туршлага	Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх; Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 4-өөс доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	- нэгжийн үйл ажиллагааны дахь эрсдэлийн нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлийг илрүүлэх, шинжлэх, дүгнэх, эрсдэлийн арга хэмжээний хувилбарыг боловсруулах, хяналт тавих; - нэгжийн албан хаагчдад ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөх, чиглүүлэх; - албан хаагчдын санал, бодлыг сонсох, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих; - үл ойлголцол, саналыг зөрүүг эв зүйгээр зохицуулах - бусад.	
	Дүн шинжилгээ хийх	- мэдээлэлд тулгуурлан, бүтэц, чиг үүргийн болон салбарын системийн шинжилгээ хийх, - харьцуулсан судалгаа хийх, судалгааны үр дүнг үнэлэх, тайлбарлах; - шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх; - бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт зөвлөмж боловсруулах; - бусад.	
	Асуудал шийдвэрлэх	- хуульд нийцсэн оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; - аливаа харилцааг хэрэгжүүлэх арга замыг хууль тогтоомж шийдвэрийн төсөлд тусгах, санал боловсруулах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд аливаа асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах;	

		- тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар тайлбарлах, зөвлөх; - бусад.
	Манлайлах	- байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх; - ёс зүйн хэм хэмжээг сахиж, хувийн зан төлөв, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, чиглүүлэх зэргээр үлгэр дуурайлал үзүүлэх; - нэгжийн үйл ажиллагаанд шинэлэг санаа, үйлчилгээг нэвтрүүлэх, албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг манлайлах; - бусад.
	Бусад	- төрийн албан хаагчийн ёс зүй, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, ажлын цагийг баримтлан ажиллах; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; - хүний эрхийн мэдрэмжтэй байх; - жендерийн эрх тэгш байдлын зарчмыг баримтлах; - албан ажлын чиг үүргийн дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр ханган ажиллах чадвартай байх; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - архив, албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх; - англи хэл, бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, засах, дүгнэлт хийх чадвартай байх; - албан ажлын хүрээнд олж авсан төр, байгууллага, хувь хүний мэдээллийг нууцлах.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

- Ахлах шинжээч-1
- Ахлах мэргэжилтэн-1
- Мэргэжилтэн-2

Нийт- 4

Бусад харилцах субъект

- Засгийн газрын хэрэг эрхлэх газар, яам, агентлаг, бусад төрийн байгууллагын газар, хэлтэс, нэгжийн холбогдох албан тушаалтан;
- Олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөр, төрийн бус байгууллагын холбогдох ажилтан;
- Мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтан, иргэн.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u> ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА /Б.БАТБАЯР/ 2025 оны дугаар сарын -ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ <u>Шийдвэрийн огноо:</u> 25-05-21 <u>Дугаар:</u> 216
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
<u>Байгууллагын нэр:</u> ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ <u>Шийдвэрийн огноо:</u> <u>Дугаар:</u> (тамга/тэмдэг) ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА /Д.ОЧИРБАТ/ 2025 оны дугаар сарын -ны өдөр	